



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 140

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын Оюуны ирээдүй цогцолбор сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын Оюуны ирээдүй цогцолбор сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 204,983.7 мянган төгрөгийн залруулаагүй зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд УСНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Дээд шатны төсвийн захирагчаас тус сургуулийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 10 удаа өөрчлөлт оруулж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал

4525020233

дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосноор цалингийн зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 17.4 хувиар өссөн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын Оюуны ирээдүй цогцолбор сургууль нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 202 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 82.5 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан Уул аймгийн ерөнхий боловсролын Оюуны ирээдүй сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/112/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дархан-Уул аймаг 2025 он</p>	<p>Газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас:70373089, 99023682 Цахим хаяг:munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас:99023682 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас:99377479 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК Захирал: Б.Жаргалсайхан Утас:99862066 Цахим хаяг:peakomaudit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчинд, дотоод орчин .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	15
4.1 Ерөнхий зүйл .....	15
4.2 Материаллаг байдал .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	17
5.1 Төлбөрийн акт .....	17
5.2 Албан шаардлага .....	18
5.3 Зөвлөмж .....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	20

### Товчилсон үгийн жагсаалт

БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,009,706,760.34</b>	<b>2,368,123,572.13</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>647,929,047.94</b>	<b>2,047,748,146.78</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>647,929,047.94</b>	<b>2,047,748,146.78</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>647,929,047.94</b>	<b>2,047,748,146.78</b>
31211	Төрийн сангийн харилцах	647,929,047.94	2,047,748,146.78
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>361,777,712.40</b>	<b>320,375,425.35</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>2,494,494.00</b>	<b>1,282,894.00</b>
35130	Эм боох материал	2,494,494.00	1,282,894.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>359,283,218.40</b>	<b>319,092,531.35</b>
35410	Бичиг хэргийн материал	2,866,480.00	3,496,273.00
35420	Аж ахуйн материал	35,461,049.95	42,163,155.95
35450	Барилгын засварын материал	54,325,911.20	120,000.00
35470	Бусад хангамжийн материал	266,629,777.25	273,313,102.40
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>13,294,515,939.30</b>	<b>13,748,760,304.89</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>13,294,515,939.30</b>	<b>13,748,760,304.89</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>11,030,031,977.58</b>	<b>11,481,724,494.71</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	11,200,723,985.73	11,200,723,985.73
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,943,020,820.29)	(2,342,147,905.21)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,759,391,081.74	1,883,763,418.19
39206	Хуримтлагдсан элэгдэл	(523,825,505.19)	(583,632,157.62)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	555,749,621.89	742,588,453.29
39208	Хуримтлагдсан элэгдэл	(255,685,513.73)	(249,489,950.74)
39214	Бусад үндсэн хөрөнгө	323,662,433.78	929,002,605.78
39215	Хуримтлагдсан элэгдэл	(207,695,627.98)	(254,818,819.68)
39217	Ном	120,732,321.63	155,734,864.97
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>2,264,483,961.72</b>	<b>2,267,035,810.18</b>
39301	Програм хангамж	17,483,572.00	22,983,572.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,799,610.28)	(8,747,761.82)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,252,800,000.00	2,252,800,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>14,304,222,699.64</b>	<b>16,116,883,877.02</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>33,316,500.00</b>	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>33,316,500.00</b>	-
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>33,316,500.00</b>	-
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>33,316,500.00</b>	-
41361	Байгууллагад төлөх өглөг	33,316,500.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>14,270,906,199.64</b>	<b>16,116,883,877.02</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>14,270,906,199.64</b>	<b>16,116,883,877.02</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	4,200,550,188.95	4,200,550,188.95
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	4,200,550,188.95	4,200,550,188.95
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(227,116,523.29)</b>	<b>1,618,861,154.09</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,121,632,909.96)	(227,116,523.29)
51220	Тайлант үеийн үр дүн	894,516,386.67	1,845,977,677.38
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,297,472,533.98	10,297,472,533.98
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>14,304,222,699.64</b>	<b>16,116,883,877.02</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>9,639,390,215.60</b>	<b>12,185,480,965.89</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,011,711,392.92</b>	<b>1,239,195,665.89</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,011,711,392.92</b>	<b>1,239,195,665.89</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>138,144,327.00</b>	<b>181,039,800.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	99,142,300.00	153,286,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,002,027.00	27,753,700.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	624,030,526.02	985,095,098.99
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	249,536,539.90	73,060,766.90
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>8,627,678,822.68</b>	<b>10,946,285,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>8,389,438,400.00</b>	<b>10,643,722,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,389,438,400.00	10,643,722,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>238,240,422.68</b>	<b>302,562,800.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	238,240,422.68	302,562,800.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>8,709,790,662.36</b>	<b>10,290,006,318.21</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>8,709,790,662.36</b>	<b>10,290,006,318.21</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>8,106,561,662.36</b>	<b>9,599,198,422.23</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>5,923,337,588.00</b>	<b>6,956,452,702.00</b>
210101	Үндсэн цалин	3,725,639,830.00	4,502,507,754.00
210102	Нэмэгдэл	1,989,381,289.00	2,108,488,264.00
210104	Урамшуулал	208,316,469.00	345,456,684.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>746,854,200.00</b>	<b>864,022,571.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	508,239,464.00	590,360,365.00
210202	Тэтгэмжийн даатгал	60,527,247.00	72,517,886.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	47,448,761.00	36,821,976.00
210204	Ажилгүйдлийн даатгал	11,718,151.00	35,533,644.00
210205	Эрүүл мэндийн даатгал	118,920,577.00	128,788,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>227,904,841.68</b>	<b>252,182,614.02</b>
210301	Гэрэл, цахилгаан	48,846,835.28	72,856,638.29
210302	Түлш, халаалт	122,945,724.64	115,662,086.78
210303	Цэвэр, бохир ус	56,112,281.76	63,663,888.95
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>57,853,400.00</b>	<b>62,248,300.00</b>
210502	Хоол, хүнс	57,853,400.00	62,248,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>154,523,928.80</b>	<b>60,865,190.00</b>
210604	Урсгал засвар	154,523,928.80	60,865,190.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>56,222,453.00</b>	<b>160,431,248.16</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,193,200.00	19,879,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	40,029,253.00	140,552,148.16
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>939,865,250.88</b>	<b>1,249,772,997.05</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	160,907,958.60	315,376,357.15
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	83,866,689.65	117,280,499.80
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	695,090,602.63	817,116,140.10
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>603,229,000.00</b>	<b>684,030,695.98</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>603,229,000.00</b>	<b>674,547,200.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	499,603,100.00	545,731,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	103,625,900.00	128,815,900.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	9,483,495.98
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	9,483,495.98
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	929,599,553.24	1,895,474,647.68
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	35,083,166.57	49,496,970.30
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	35,083,166.57	49,496,970.30
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	894,516,386.67	1,845,977,677.38

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	8,765,823,149.68	11,127,325,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	138,144,327.00	181,039,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	138,144,327.00	181,039,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	138,144,327.00	181,039,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	99,142,300.00	153,286,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,002,027.00	27,753,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,627,678,822.68	10,946,285,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,389,438,400.00	10,643,722,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,389,438,400.00	10,643,722,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	238,240,422.68	302,562,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	238,240,422.68	302,562,800.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,851,564,414.68	9,581,910,338.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,851,564,414.68	9,581,910,338.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,247,758,614.68	8,901,647,242.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,923,337,588.00	6,956,452,702.00
210101	Үндсэн цалин	3,725,639,830.00	4,502,507,754.00
210102	Нэмэгдэл	1,989,381,289.00	2,108,488,264.00
210104	Урамшуулал	208,316,469.00	345,456,684.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	746,854,200.00	864,022,571.00
210201	Тэтгэврийн даатгал	508,239,464.00	590,360,365.00
210202	Тэтгэмжийн даатгал	60,527,247.00	72,517,886.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	47,448,761.00	36,821,976.00
210204	Ажилгүйдлийн даатгал	11,718,151.00	35,533,644.00
210205	Эрүүл мэндийн даатгал	118,920,577.00	128,788,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	227,904,841.68	252,182,614.02
210301	Гэрэл, цахилгаан	48,846,835.28	72,856,638.29
210302	Түлш, халаалт	122,945,724.64	115,662,086.78
210303	Цэвэр, бохир ус	56,112,281.76	63,663,888.95
2105	Нормативт зардал	57,276,600.00	62,248,300.00
210502	Хоол, хүнс	57,276,600.00	62,248,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,986,960.00	60,865,190.00
210604	Урсгал засвар	25,986,960.00	60,865,190.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,704,853.00	184,186,792.16
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,976,200.00	19,879,100.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	42,728,653.00	164,307,692.16
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>204,693,572.00</b>	<b>331,754,759.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	130,455,758.00	227,242,681.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	74,237,814.00	104,512,078.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>603,805,800.00</b>	<b>684,030,695.98</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>603,805,800.00</b>	<b>674,547,200.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	500,179,900.00	545,731,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	103,625,900.00	128,815,900.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>9,483,495.98</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	9,483,495.98
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>914,258,735.00</b>	<b>1,545,414,761.82</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>342,963,552.00</b>	<b>331,762,377.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>342,963,552.00</b>	<b>331,762,377.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>342,963,552.00</b>	<b>331,762,377.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	342,963,552.00	331,762,377.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(342,963,552.00)</b>	<b>(331,762,377.00)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>571,295,183.00</b>	<b>1,213,652,384.82</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	76,633,864.94	647,929,047.94
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	647,929,047.94	2,047,748,146.78

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,200,550,188.95	10,297,472,533.98	(1,121,632,909.96)	13,376,389,812.97
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,200,550,188.95	10,297,472,533.98	(1,121,632,909.96)	13,376,389,812.97
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	894,516,386.67	894,516,386.67
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,200,550,188.95	10,297,472,533.98	(227,116,523.29)	14,270,906,199.64
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,200,550,188.95	10,297,472,533.98	(227,116,523.29)	14,270,906,199.64
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,200,550,188.95	10,297,472,533.98	(227,116,523.29)	14,270,906,199.64
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	1,845,977,677.38	1,845,977,677.38
20	2024 оны 12-р сарын 30-наарх үлдэгдэл	4,200,550,188.95	10,297,472,533.98	1,618,861,154.09	16,116,883,877.02

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	11,810,682,700.00	9,718,022,505.18	(2,092,660,194.82)	82.28
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	11,810,682,700.00	9,718,022,505.18	(2,092,660,194.82)	82.28
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	11,090,588,500.00	9,047,242,905.18	(2,043,345,594.82)	81.58
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	8,525,523,000.00	6,956,452,702.00	(1,569,070,298.00)	81.60
210101	Үндсэн цалин	6,078,996,100.00	4,502,507,754.00	(1576488346.00)	74.07
210102	Нэмэгдэл	2,176,751,200.00	2,108,488,264.00	(68262936.00)	96.86
210104	Урамшуулал	269,775,700.00	345,456,684.00	75,680,984.00	128.05
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	1,065,690,400.00	864,022,571.00	(201,667,829.00)	81.08
210201	Тэтгэврийн даатгал	724,669,400.00	590,360,365.00	(134,309,035.00)	81.47
210202	Тэтгэмжийн даатгал	85,255,100.00	72,517,886.00	(12,737,214.00)	85.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	42,627,700.00	36,821,976.00	(5,805,724.00)	86.38
210204	Ажилгүйдлийн даатгал	42,627,700.00	35,533,644.00	(7,094,056.00)	83.36
210205	Эрүүл мэндийн даатгал	170,510,500.00	128,788,700.00	(41,721,800.00)	75.53
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	280,164,400.00	252,182,614.02	(27,981,785.98)	90.01
210301	Гэрэл, цахилгаан	78,000,000.00	72,856,638.29	(5,143,361.71)	93.41
210302	Түлш, халаалт	133,601,600.00	115,662,086.78	(17,939,513.22)	86.57
210303	Цэвэр, бохир ус	68,562,800.00	63,663,888.95	(4,898,911.05)	92.85
2105	<b>Нормативт зардал</b>	94,872,900.00	62,248,300.00	(32,624,600.00)	65.61
210502	Хоол, хүнс	94,872,900.00	62,248,300.00	(32,624,600.00)	65.61
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	130,000,000.00	121,270,777.50	(8,729,222.50)	93.29
210601	Багаж, техник, хэрэгсэл	39,500,000.00	38,628,811.50	(871,188.50)	97.79
210602	Тавилга	29,500,000.00	21,776,776.00	(7,723,224.00)	73.82
210604	Урсгал засвар	61,000,000.00	60,865,190.00	(134,810.00)	99.78
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	273,242,300.00	193,843,975.16	(79,398,324.84)	70.94
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,000,000.00	19,879,100.00	(4,120,900.00)	82.83
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	249,242,300.00	173,964,875.16	(75,277,424.84)	69.80
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	721,095,500.00	593,454,365.50	(127,641,134.50)	82.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	614,091,600.00	486,984,287.50	(127,107,312.50)	79.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	107,003,900.00	106,470,078.00	(533,822.00)	99.50
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	720,094,200.00	674,547,200.00	(45,547,000.00)	93.67
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	720,094,200.00	674,547,200.00	(45,547,000.00)	93.67
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	590,173,300.00	545,731,300.00	(44,442,000.00)	92.47
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	129,920,900.00	128,815,900.00	(1,105,000.00)	99.15
1	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	11,810,682,700.00	11,117,841,604.02	(692,841,095.98)	94.13
131	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	11,290,518,300.00	10,643,722,500.00	(646,795,800.00)	94.27

131001	Улсын төсвөөс санхүүжих	10,643,722,500.00	10,643,722,500.00	0.00	100.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	646,795,800.00	0.00	(646,795,800.00)	0.00
<b>132</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>321,164,400.00</b>	<b>293,079,304.02</b>	<b>(28,085,095.98)</b>	<b>91.26</b>
320001	Орон нутгийн төсвөөс	321,164,400.00	293,079,304.02	(28,085,095.98)	91.26
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>199,000,000.00</b>	<b>181,039,800.00</b>	<b>(17,960,200.00)</b>	<b>90.97</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	139,000,000.00	153,286,100.00	14,286,100.00	110.28
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	60,000,000.00	27,753,700.00	(32,246,300.00)	46.26
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	647,929,047.94	647,929,047.94	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	2,047,748,146.78	2,047,748,146.78	0.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>276.00</b>	<b>266.00</b>	<b>(10.00)</b>	<b>96.38</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	245.00	229.00	(16.00)	93.47
620003	Үйлчлэх ажилтан	40.00	36.00	(4.00)	90.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>5,460.00</b>	<b>5,465.00</b>	<b>5.00</b>	<b>100.09</b>
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	<b>5,460.00</b>	<b>5,465.00</b>	<b>5.00</b>	<b>100.09</b>
630001	Төрийн өмчит ЕБС	5,460.00	5,465.00	5.00	100.09

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй байна.

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын Оюуны ирээдүй сургууль нь 2024-2025 хичээлийн жилийн эрхэм зорилгоо “Зөв хандлага төлөвшилтэй, бүтээлч суралцагч, бүх талын хамтын ажиллагаа, оролцоог дэмжин, сургалтын идэвхтэй аргуудаар цахим болон танхимын хосолсон сургалтыг үр дүнтэй зохион байгуулна” гэж тодорхойлон үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тус сургууль нь хүүхдийн бие даан суралцах үйлийг дэмжин амжилттай суралцахад эцэг эх багшийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэн суралцагч өөрийгөө үнэлэн, ахицаа тооцох боломжийг бүрдүүлж, тэгш суралцах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Хамтын оролцоотойгоор сургуулийн менежментийг сайжруулж, суралцагчдын сурч хөгжих нийгэм сэтгэл зүйн таатай орчинг эцэг, эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоонд тулгуурлан бүрдүүлж, эерэг уур амьсгал, соёл төлөвшүүлэх,
- Багшийн мэргэжлийн хөгжлийн бүлгийг багш нарын хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн байгуулж, судалгаанд суурилан хичээлийн залгамж холбоог сайжруулах, багшийг чадавхжуулах,
- Багш бүр ээлжит хичээлийн төлөвлөлт болон сургалтын үйл ажиллагаандаа суралцагчийн уншиж ойлгох, бичих, хэрэглээний чадварыг нэмэгдүүлж, ахиц гаргах,

- Математик, англи хэлний сургалтыг дэмжих цахим платформд суурилсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх,
- Сургуулийн орчинд гарсан харилцааны зөрчил, үе тэнгийн дарамт дээрэлхэлтийн өнөөгийн байдлыг судлан, шинжилгээ хийж, төлөвлөлт гарган ажиллах,
- Дунд, ахлах ангийн суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаатай болгоход зөвлөн тусалж, эрүүл зөв дадал, хэвшил төлөвшүүлэх,
- Эцэг эх, асран хамгаалагчийн оролцоо, дэмжлэгтэйгээр хүүхдийн өсөлт, эрүүл мэндийг дэмжин ажиллах,

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчинд, дотоод орчин**

Тус сургууль нь Боловсролын ерөнхий хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад эрхийн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор "Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам" ;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор "Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам";
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 82 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын Оюуны ирээдүй сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд Нягт Гүйцэтгэл ХХК-ний 2022 онд боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж өөрийн байгууллагын онцлог нөхцөлд тулгуурлан хууль эрх зүйн орчин болон, үйл ажиллагааныхаа хүрээнд нэмэлт өөрчлөлтүүдийг тушаал гарган хавсаргасан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын Оюуны ирээдүй сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн цалин хөлсний бодлогод МУ-ын ЗГ-ын тогтоолын дагуу өөрчлөлт орсон.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,812,661.2 мянган төгрөгөөр буюу 12,67 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	647,929.0	2,047,748.1	1,399,819.1
Авлага	-	-	-
Бараа материал	361,777.7	320,375.4	(41,402.3)
Үндсэн хөрөнгө	13,294,515.9	13,748,760.3	454,244.4
Нийт хөрөнгө	14,304,222.7	16,116,883.9	1,812,661.2
Богино хугацаат өр төлбөр	33,316.5	-	(33,316.5)
Эздийн өмчийн дүн	14,270,906.2	16,116,883.9	1,845,977.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	14,304,222.7	16,116,883.9	1,812,661.2

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,047,748.1 мянган төгрөг болж өмнөх оноос 1,399,819.1 мянган төгрөгөөр өссөн нь тухайн байгууллагын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 8.7-д “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

Тайлант онд бараа материалын дансны үлдэгдэл 320,375.4 мянган төгрөг болж 41,402.3 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 259,196.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Өвөр тасархай ХХК-аас 6,309.7 мянган төгрөгийн вакум цонх хаалтыг хандив тусламжаар, Боловсролын яамнаас 61,248.6 мянган төгрөгийн цахим хичээлийн хэрэглэгдэхүүн, ном сурах бичиг, Боловсролын газраас 5,502.5 мянган төгрөгийн ном сурах бичиг нийт 66,751.1 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй шилжүүлэн авч, 373,659.8 мянган төгрөгийн бараа материал үйл ажиллагаандаа зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 13,748,760.3 мянган төгрөг болж өссөн байна. Тодруулбал төсвийн хөрөнгө, нөхөн хангалтын зардалаар 335,762.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, Боловсрол яамнаас 37,765.5 мянган төгрөгийн цахим сурах бичиг, ном сурах бичиг хичээлийн хэрэглэгдэхүүн, Боловсролын газраас орон нутгийн сангийн хөрөнгө оруулалтаар 21,288.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 62,107.2 мянган төгрөгийн сурагчийн ширээ сандал, Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны 12 сарын 04 өдрийн тушаалаар орон нутгийн сангийн хөрөнгө оруулалтаар 602,340.2 мянган төгрөгийн хичээлийн Б байрны иж бүрэн гадна талбайг үнэ төлбөргүй хүлээн авсан, Чусоны их сургуулиас 29,620.0 мянган төгрөгийн солонгос хэлий анги тохижуулах тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, сурагч нарын эцэг эхчүүдүүс 39,274.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшилийг хандиваар хүлээн авсан, Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны 06 сарын 20 өдрийн А/16 тоот тушаалаар үндсэн хөрөнгийн ашиглах жилийг шинэчлэн тогтоож 192,699.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгүүдийг холбогдох тушаал шийдвэрээр хөрөнгийн дансуудад орлогоор бүртгэн авсан байна. Мөн аймгийн Засаг даргын 2024 оны 07-р сарын 03-ны өдрийн 01-А/313 тоот захирамжаар 185,985.8 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, Орон нутгийн өмчийн газрын даргын хөрөнгө шилжүүлэх 2024 оны 06 сарын 20 өдрийн А/18 тоот тушаалаар 17,863.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шилжүүлэн,

тайлант хугацаанд 817,116.1 мянган төгрөгийн элэгдэл тооцож, зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 33,316.5 мянган төгрөгөөр буурсан нь 2023 онд Юнившин компаниас 24 сарын хугацаатай зээлээр худалдан авалт хийсэн хөрөнгийн үлдэгдэл төлбөрийг барагдуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 16,116,883.9 мянган төгрөг болж 1,845,977.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургууль нь 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 11,879,132.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 396,250.3 мянган төгрөг, нийт зарлагыг 12,275,382.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг улсын төсвийн санхүүжилтийг 3,621,999.8 мянган төгрөгөөр бууруулж 8,257,132.4 мянган төгрөг, орон нутгийн төсвийг 321,164.4 мянган төгрөг, нийт 8,578,296.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийн хуваарьт 10 удаа өөрчлөлт орж, улсын төсвийг 3,553,550.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгол хийсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 16 арга хэмжээг санхүүжүүлэхээр 10,643,722.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 321,164.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 139,000.000 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 60,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, 646,795.8 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, нийт 11,810,682.7 мянган төгрөгийн эх үүсвэр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 10,643,722.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 302,562.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 153,286.1 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 27,753.7 мянган төгрөг, нийт 11,127,325.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарлагын гүйцэтгэл 9,718,022.5 мянган төгрөг буюу 82.2 хувьтай зарцуулж, 9,483.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, зарцуулаагүй үлдсэн 1,390,335.6 мянган төгрөгийн үлдэгдлээр тайлагнасантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Код	Нэр				
1	80111	Тогтмол зардал	341,164,400.00	313,047,804.02	(28,116,595.98)	91.76
2	80226	Байр ашиглалт үйлчилгээ	26,751,000.00	26,751,000.00	0.00	100.00
3	80233	Хүүхэд хамгаалал	25,065,400.00	19,127,640.00	(5,937,760.00)	76.31
4	80312	Сургалт семинарын зардал	21,411,700.00	11,585,500.00	(9,826,200.00)	54.11
5	81605	Эрүүл мэндийг дэмжих зардал	42,655,800.00	10,080,000.00	(32,575,800.00)	23.63
6	81801	Үдийн цай хөтөлбөр	590,173,300.00	545,731,300.00	(44,442,000.00)	92.47
7	81806	Дотуур байрны хүүхдийн хоол	268,547,807.00	151,571,127.00	(116,976,680.00)	56.44
8	81816	Хүүхдэд ээлтэй орчин	158,426,000.00	158,426,000.00	0.00	100.00
9	81823	Багшийн мэргэжил дээшлүүлэх зардал	81,453,100.00	24,244,400.00	(57,208,700.00)	29.76
10	81834	Боловсролын стандарт	9,493,264,396.94	7,783,183,005.90	(1,710,081,391.04)	81.99
11	81835	Сургалт хэвийн үйл ажиллагаа хангах	502,050,200.00	502,050,200.00	0.00	100.00

12	81875	Сургуулийн нэмэлт хөтөлбөр	186,321,748.06	154,102,135.00	(32,219,613.06)	82.71
13	81844	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалт	7,879,300.00	7,879,100.00	(200.00)	100.00
14	81848	Сурах бичгийн түрээс	65,338,600.00	10,118,293.26	(55,220,306.74)	15.49
15	83602	ЗГ болон ЗД нөөц сангаас	125,000.00	125,000.00	0.00	100.00
16	83603	Нэмэлт дээд шатнаас хуваарилсан	54,948.00	-	(54,948.00)	0.00
Нийт дүн			11,810,682,700.00	9,718,022,505.18	(2,092,660,194.82)	82.28

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ байхгүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

### Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл:

2024 оны худалдан авах ажиллагааг урсгал төсвийн хүрээнд хуулийн дагуу хугацаанд нь tender.gov.mn, shilendans.gov.mn сайтуудаар байршуулан нийтэлж, тайланг цахим болон цаасаар хүргүүлж ажилласан байна. tender.gov.mn сайтад хүүхдийн хоол хүнсний нээлттэй тендер шалгаруулалтыг тайлагнаж ажилласан байна. Хүүхдийн үдийн цайны үйлчилгээ тендер, дотуур байрны сурагчдын хоол хүнсээр хангах үйлчилгээ үзүүлэх нээлттэй тендер шалгаруулалтыг тайлант онд хуулийн хугацаанд зарлан, тухайн 2 тендерт Өвөр тасархай ХХК санал ирүүлэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гэрээ байгуулан ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын Оюуны ирээдүй цогцолбор сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2025 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хооронд Пийк Ом Аудит ХХК-ын аудитор А.Батболд гүйцэтгэж, захирал Б.Жаргалсайхан хянан удирдаж, чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын Оюуны ирээдүй сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк-Ом Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 33 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардал 8,710,455.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 87,104.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрээс 192.775.3 мянган төгрөгийн 12 шийдвэр тус тус мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана:”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 31,478.9 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 1 төлбөрийн акт, 5 зөвлөмж өгснөөс 1 төлбөрийн актыг барагдуулан, 4 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт	Биелэлт
----------	------------------------	---------

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	387.0	1	387.0	100
Зөвлөмж	5	31,091.9	4	31,091.9	80
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>31,478.9</b>	<b>5</b>	<b>31,478.9</b>	<b>83,3</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Тус сургуулийн Б байрны 122,669.8 мянган төгрөгийн дээвэр засварын ажлыг 2024-11-25 өдрийн улсын комиссын шийдвэрээр байнгын ашиглалтад хүлээн авсан. Тайланд онд холбогдох байгууллагыг тушаал шийдвэр гаргаагүй гэх үндэслэлээр санхүүгийн тайланд орлого аваагүй байна.

2. Үйлдвэрлэлийн ослын нөхөн олговор 21,000.0 мянган төгрөгийг цалингийн сангаас олгосон нь төсвийн гүйцэтгэлээр цалингийн зардал хэтрэх, эдийн засгийн ангилал төлөвлөгөөгүй зардал гарч цалин хөлсний тооцоотой өр төлбөр үүсэх эрсдэлтэй байна .

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 386,656.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 181,672.8 мянган төгрөгийн 7 алдааг аудитын явцад залруулж, 2,243.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 200,740.7 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 2,000.0 мянган төгрөгийн дахин давтан гаргахгүй байх 4 зөрчилд зөвлөмж өглөө.

Аудитын явцад дараах Алдаануудыг залруулсан. Үүнд:

- Бичиг хэргийн материалын дансаас 15,624.3 мянган төгрөгийн 1,943 ширхэг бичиг хэргийн материалыг зардалд тусгаж гүйлгээ хийгээгүй.,
- Барилгын засварын материалын дансаас 88,835.4 мянган төгрөгийн 3330 ширхэг барилгын материалыг зардалд тусгаж гүйлгээ хийгээгүй.
- Бусад хангамжийн материалын дансаас 7,366.5 мянган төгрөгийн 228 ширхэг хангамжийн материалыг зардалд тусгаж гүйлгээ хийгээгүй,
- Барилгын засварын материал дансанд хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажлын 35,926.8 мянган төгрөгийн 2707 ширхэг дээврийн засварын материалыг орлого авсан,
- Чусоны их сургууль болон 2023-2024 эцэг эхчүүдээс хандиваар ирсэн 16,860.0 мянган төгрөгийн 7 ширхэг сургалтын тоног төхөөрөмжийг тавилга эд хогшилын дансанд бүртгэсэн,
- БШУЯ-ны санхүүжилтээр үнэ төлбөргүй шилжиж ирсэн 3,354.8 мянган төгрөгийн хөрөнгийн холбогдох дансанд бүртгэж аваагүй,
- Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлан 13,705.1 мянган төгрөгөөр буруу илэрхийлэгдэсэн,

Санхүүгийн тайланг нийт 181,672.8 мянган төгрөгийн алдаатай тайлагнасан нь УСНББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", УСНББОУС 12 "Бараа материал", УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө", Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам", "Ангилал", "Толилуулга", батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулав.

#### 5.1 Төлбөрийн акт

1. 2024 оны 4-р сараас сургуулийн захиралын ажил хавсран гүйцэтгэгч П.Байгалмаад, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлтээр өөрчлөлтгүй дүгнэгдсэн гэх үндэслэлээр 2,243.0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал илүү бодож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй ба үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Албан шаардлага

1. Сургуулийн санхүүгийн ажилтнуудад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 10,697.0 мянган төгрөгийн балансын урамшуулал олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна гэж" заасантай тус тус нийцээгүй тул зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан, жилийн эцсийн тооллогын үр дүнг 12 сарын 31-ний үлдэгдлээр тохируулдаггүй, тооллогын илтгэх хуудас болон тайланг үндсэн хөрөнгө, бараа материалын ангилал тус бүрээр дэлгэрэнгүй бодитой бичээгүй, тооллогын хуудсыг батлагдсан маягтын дагуу бэлтгэж, санхүүгийн программаас үлдэгдлийг хуулж бичдэг, өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт, тооллогын комиссын тайлан мэдээг цаг хугацаанд нь тайлагнаж дүгнэлт гаргаагүй, тооллого хийсэн протокол нь тооллогын шаардлагад нийцэхгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт бүртгэлээр тавих хяналтыг ерөнхий нягтлан бодогч хариуцна", 70.2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн тогтоосон хугацаанд явуулж, улирал жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнах", 72.4-д "Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв чанартай явуулж дуусгах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь НББ хөтлөх, санхүүгийн тайлан мэдээг үнэн зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтад нийцэхгүй байна. гэсэн заалтуудыг зөрчсөн ба "Үнэн зөв" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Тус сургууль сургалтын орчин болон цахим орчныг бүрдүүлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, компьютер түүний дагалдах хэрэгслийг худалдан авах, нөхөн хангалтын зардлыг зарцуулахдаа, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргаагүй, шилэн дансанд байршуулаагүй, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчин худалдан авалт хийсэн, нөхөн хангалтын зардалын зарцуулалтыг холбогдох журам мөрдөж ажиллаагүй 190,043.7 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль 8 дугаар зүйлийн 8.2 "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", 8.13 "Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно", 10.3 "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт 7.7.4. "Энэ аргачлалын 7.7.3-т заасны хүрээнд төсвийн шууд захирагч нь тухайн сургалтын байгууллагад хуваарилагдах тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлаар шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авах хэрэгцээг эрэмбэлж, үе шаттай шийдвэрлэх төлөвлөгөө баталж, шийдвэрлэх", 7.7.6. "Эрх бүхий байгууллагын холбогдох шийдвэрийн дагуу нөхөн хангалтын хүрээнд шаардлагатай сургалтын тоног төхөөрөмжийг худалдан авах ажиллагааг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран ерөнхий гэрээний аргаар хийх", Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалаар баталсан "Хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ын 3.3 дахь заалт, "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ын 3.1 дэх заалт, "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх заавар, аргачлал"-ын 2.2.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн тул зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

## 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

## 1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Бараа материалын орлого, зарлагыг ажил гүйлгээг бараа материалын тайланд гүйлгээ гарах бүрт хөдөлгөөн хийдэггүй, илүү, дутуу гүйлгээ хийгдэг, урсгал зардалд зарцуулсан материалын ажлын тайлан гүйцэтгэл, байхгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9. "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах", Сангийн сайдын 2025 оны А/З дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 10 дугаар бүлэгт "Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг стандартыг мөрдөнө" заалтуудыг зөрчсөн ба "Үнэн зөв" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын орлого, зарлагын гүйлгээнд хяналт тавьж ажиллах. мөн алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

## 2. Цалингийн данстай холбоотой асуудал

Ажлаас чөлөөлсөн ажилтан нарт илүү олгосон цалинг, тухайн ажилтан нараас суутган тооцоо хийгээгүй, одоо ажиллаж байгаа ажилтан нарын цалингаас 2,000.0 мянган төгрөгийн суутган тооцож байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Ажлаас чөлөөлөгдөж байгаа ажилтан нартай тойрох хуудсаар тооцоо нийлж баталгаажуулах, мөн алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

## 3. Гэрээний хэрэгжилт

Тайлант жилд байгуулласан хамтран ажиллах гэрээнүүдийг дүгнээгүй, тооцоо нийлсэн акт үйлдээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "хариуцлагатай байх", 16 дугаар зүйлийн 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтуудтай тус тус нийцэхгүй ба үнэлгээ ба хуваарилалт, толилуулга ба тодруулга, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харилцагч байгууллагатай тооцоо нийлсэн актыг тогтмол хийж, гэрээг дүгнэх, мөн алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

## 4. Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт

Тус сургууль нь хууль тогтоомжийн хүрээнд ахмадын сан байгуулаагүй нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган, цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах", Ахмадын сан байгуулан ажиллуулах журмын 1.3 дахь "Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу ахмадын санг байгуулах, мөн алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 -д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бичиг хэргийн материалыг зардалд тусгаж гүйлгээ хийгээгүй.	1	15,624.3	1	15,624.3			1	15,624.3				
Барилгын материалыг зардалд тусгаж гүйлгээ хийгээгүй.	1	88,835.4	1	88,835.4			1	88,835.4				
Хангамжийн материалыг зардалд тусгаж гүйлгээ хийгээгүй.	1	7,366.5	1	7,366.5			1	7,366.5				
Дээврийн засварын материалыг орлого авсан.	1	35,926.8			1	35,926.8	1	35,926.8				
Сургалтын тоног төхөөрөмжийг 39207 тоот дансанд бүртгэсэн.	1	16,860.0			1	16,860.0	1	16,860.0				
Хөрөнгийн холбогдох дансанд бүртгэж аваагүй.	1	3,354.8	1	3,354.8			1	3,354.8				
Тайлант үеийн үр дүн буруу илэрхийлэгдэсэн	1	13,705.1			1	13,705.1	1	13,705.1				
	7	181,672.8	4	115,181.0	3	66,491.8	7.0	181,672.8	-	-	0	0

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Урсгал зардалд зарцуулсан материалын ажлын тайлан гүйцэтгэл, байхгүй	1	-					1.0	-				
Тухайн ажилтан нараас суутган тооцоо хийгээгүй, одоо ажиллаж байгаа ажилтан нарын цалингаас суутган тооцсон	1	2,000.0					1.0	2,000.0				
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчин худалдан авалт хийсэн	1	190,043.7			1.0	190,043.7						

Тооллогын үр дүнг дүгнээгүй, тайлан мэдээг бүрэн гаргаагүй, өмч хамгаалах байнгын зөвлөл хурал хийж үр дүнг тайлагнаагүй	1	-			1.0	-						
Балансын урамшуулалыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан цалингийн зардлаас олгосон.	1	10,697.0			1.0	10,697.0						
Мөнгөн урамшуулал илүү бодож олгосон	1	2,243.0	1	2,243.0								
Гэрээ дүгнээгүй, тооцоо нийлсэн акт үйлдээгүй	1						1					
Дүн	7	204,983.7	1	2,243.0	3	200,740.7	3	2,000.0	0			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрээс 192.775.3 мянган төгрөгийн 12 шийдвэр тус тус мэдээлээгүй байна	1	192,775.3			1	192,775.3		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>192,775.3</b>			<b>1</b>	<b>192,775.3</b>		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Ахмадын сан байгуулаагүй	1	0.0					1	0.0
Тайлант жилд байгуулласан хамтран ажиллах гэрээнүүдийг дүгнээгүй, тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна.	1	0.0					1	0.0
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>2.0</b>	<b>0.0</b>
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>192,775.3</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>1.0</b>	<b>192,775.3</b>	<b>2.0</b>	<b>0.0</b>